



1.1 Монгол орны газарзүйн байрлал.

8-Р АНГИ- 1Р БҮЛЭГ МО-НЫ ГАЗАРЗҮЙН ОНЦЛОГ.

Энэ хичээлийн хүрээнд:

1. Монгол орны газарзүйн байрлалын онцлог.
2. Монгол орны захын цэгүүд.
3. Монгол орны төв цэг.
4. Монгол орны гадаргын ерөнхий онцлог.



1.Монгол орны газарзүйн байрлалын онцлог.

Монгол орон Ази тивийн төв хэсэгт өргөргийн дагуу сунаж байрласан бөгөөд хойт өргөргийн $41^{\circ}35' - 52^{\circ}09'$, зүүн уртрагийн $87^{\circ}44' - 119^{\circ}56'$ -ийн хооронд 1564 мян.ам.дөр.км талбайг эзлэн оршдог нь дэлхийн хуурай газрын бараг 1%-тай тэнцэнэ.

Нутгийн баруун захын цэгээс зүүн захын цэгийн хооронд 2392 км, хойд захын цэгээс урд захын цэгийн хооронд 1259 км зайтай,хилийн шугамын урт 8216 км үүнээс 3485 км нь ОХУ-тай үлдэх 4731 км-ээр БНХАУ-тай хиллэнэ.






2. Монгол орны захын цэгүүд.


Таван Богд уул, Тарваган Дах овоо энэ хоёр нь Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хилийн 3 улсын уулзвар цэг юм. 4 захын цэг:

1. Баруун захын цэг-Алтай Таван Богдын Мааньт уул
2. Зүүн захын цэг-Соёлз уулын Модот Хамар
3. Хойт захын цэг-Монгол Шарын даваа
4. Өмнөд захын цэг-Орвог Гашууны Бор толгой юм.



3. Монгол орны төв цэг.

Монгол орны нутгийн төв, хүйс цэг нь Өвөрхангай аймгийн Бүрд сумын төвөөс урагш 18км-т Өвөр хөшөөтийн булаг гэх газар оршино.



4. Монгол орны гадаргын ерөнхий онцлог.

Монгол улсын нутаг дэвсгэр нь бүтнээрээ Төв Азид хамрагдах бөгөөд баруунаас зүүн тийш сунаж байрласан улсын хойт, урд хоёр захын цэгийн хоорондох зай өргөргийн 10° хүрдэг. Уур амьсгалын хувьд сэрүүн бүсэд хамаарагдана.

Монгол орны нутаг дэвсгэрийн газрын гадарга янз бүрийн хэлбэр дүрстэй, өндөр уулс, нам уулс, ухаа гүвээ, цав толгод өргөн уудам тал, хөндий, хотгор хосолсон ой тайга, хээр, говь, цөл бүхий далайн төвшнөөс дээш дунджаар 1580 метр өргөгдсөн нь байдаг. Нутаг дэвсгэрийн 80% нь далайн төвшнөөс 1000 гаруй метр өндөрт орших бөгөөд баруун хэсэгтээ далайн төвшнөөс дээш дунджаар 2500-3500 метр өргөгдсөн оргил бүхий Монгол Алтай, Говь Алтайн нуруу, нутгийн баруун болон хойд талаар 2000-2500 метр өндөр Хангай, Хэнтэй нуруу, Хөвсгөлийн уулс оршино. Харин зүүн ба өмнөд хэсгээр 1000-1500 метр өндөртэй Дорнод Монголын тал, нам уулс, цав толгод бүхий говь нутгаас бүрдэнэ.

Монгол орны гадаргын ерөнхий онцлог.

1. Манай орны хамгийн өндөр цэг нь Монгол Алтайн нурууны ноён оргил Хүйтэн 4374 метр, хамгийн нам цэг нь Дорнод Монголын тал дахь Хөх нуурын хотгор 562 метр юм. Тус улсын нутаг дэвсгэрийн газрын гадарга Сибирийн өмнөд уулсаас Төв Азийн тал газарт шилжих шилжилтийн мужид, умар зүгийн хүйтэн чийглэг уур амьсгалаас өмнө зүгийн хэт хуурай уур амьсгалд шилжих алгуур шилжилтийн нөхцөлд бүрэлдэн тогтжээ.
2. Монгол Алтай, Хангайн нурууны хооронд Их Нууруудын хотгор гэж нэрлэгдэх уудам хотос орших бөгөөд тус орны том, томоохон нуурууд Увс, Хяргас, Хар Ус, Хар, Айраг, Дөргөн нуур оршино.
3. Нуурт цутгадаг голууд нуурын хотгорт голдуу элсэн хурдас их хэмжээгээр авчран тунааж байсан, одоо ч тунаасаар байгаа учраас эдгээр голын хөндийд элсэрхэг өргөн тал газар үүсч, салхины нөлөөгөөр Бөөрөг Дэл, Бор Хар, Монгол элс зэрэг томоохон элсэн тарамцаг хэлбэржин тогтсон байна.

Монгол орны гадаргын ерөнхий онцлог.

4. Тус орны хойт хэсэгт орших Хөвсгөлийн уулс гарал үүслээрээ Байгаль нуурын орчмын уулсын тогтолцоонд хамрагдах бөгөөд уулсын хоорондох ан цавыг дагаж тогтсон Хөвсгөл, Дархадын гэсэн хоёр том хотгороор тусгаарлагдан уртрагын дагуу сунаж байрласан нуруудаас бүрдэнэ. Хөвсгөлийн хотгорт тус орны хамгийн гүн, цэнгэг, усны нөөцөөр арвин Хөвсгөл нуур оршдог бол Дархадын хотгорт нуурын гаралтай тал, олон зуун жижиг нуур, голын хөндий зонхилж, голуудаас том нь Енисей мөрний эх Шишхид гол урсана

5. Уг бүсээс урагшаа Монгол орны төв хэсэгт Хангайн нуруу баруун хойноос зүүн урагш сунаж байрлах ба түүний бүрэлдэхүүнд Булнай, Тарвагатай, Бүрэн зэрэг хэд хэдэн томоохон нурууд багтах ба ноён оргил нь нурууны баруун хэсэгт орших Отгонтэнгэр 4021 метр өндөр юм.

6. Нууруудын хөндийгөөс урагш Говь Алтай нуруу хэд хэдэн салангид нуруудаас бүрдэж 800 гаруй км үргэлжлэх ба ихээхэн нарийн тогтоцтой. Энд хамгийн өндөр цэг нь Их Богд уул 3957м юм.

7. Хангайн нуруунаас зүүн тийш Хэнтэй нуруу орших ба хамгийн өндөр оргил нь Асралт хайрхан 2800 метр, энэ нуруу нь нийтдээ тархай байдалтай, тэгшивтэр оройтой олон жижиг нуруудаас бүрдсэн байдаг.


Монголын зүүн зах Халх голын савд Их Хянганы нурууны салбар болох хүрмэн чулуун бэгэлцэг, боржин тарамцагаас тогтсон нам уулс байрлах бөгөөд эртний голын хөндий элбэг, дэнжээр нь элс тархана. Халхын гол болон түүний цутгал голын хөндий, тэр орчмын үржил шимтэй тал газар хөдөө аж ахуйд тохиромжтой чухал нөөц нутагт тооцогдоно. Тус орны гадаргын дээрх онцлог шинж нь газар нутагт өөр өөр байх нөхцөлийг бүрдүүлсний зэрэгцээ байгалийн хэд хэдэн бүс үүсгэнэ.



Монгол орны гадаргын ерөнхий онцлог.

1. МО-ны хамгийн өндөр цэг
х.ө $49^{\circ} 08$, з.у $87^{\circ} 49$ - Монгол
Алтайн Хүйтэн уул д.т.д 4374м.

2. МО-ны хамгийн нам цэг х.ө
 $49^{\circ} 30$, з.у $115^{\circ} 34$ - Хөх нуур
д.т.д 560м.



МОНГОЛ АЛТАЙН НУРУУ



ХЭНТИЙН НУРУУ



ИХ ХЯНГАНЫ НУРУУНЫ САЛБАР УУЛС



